



**ДОРНОГОВЬ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2024.02.23 № 1-6/96  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ ДАРГА  
С.ГАН-ОД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн төсрөлтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Тайлант онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бараа материалын дансанд ангиллын дагуу бүртгээгүй 11 нэр төрлийн 1.6 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүртгэсэн байсныг завсрын аудитын явцад залруулах чиглэл өгсөн боловч гүйцэтгэх шатанд залруулга хийж ажиллаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын

010020201

4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно”, 4.16-д –“Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө”, 4.29-д “ Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ыг дагаж мөрдөнө” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн Засаг дарга, Нийгмийн даатгалын хооронд байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 зорилт, 8 хөтөлбөрийн 51 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн биелэлт 87.4 хувьтай байна.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,220,808,010.30</b>	<b>16,467,109,225.26</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,545,044,603.18</b>	<b>9,582,876,176.75</b>
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,545,044,603.18</b>	<b>9,582,876,176.75</b>
31210	<b>Төгрөг</b>	<b>6,545,044,603.18</b>	<b>9,582,876,176.75</b>
31211	Төрийн сангийн харилцах	7,363,682.21	1,522,878.00
31213	Арилжааны банк дахь харилцах	6,537,680,920.97	9,581,353,298.75
33	<b>АВЛАГА</b>	<b>6,656,385,337.51</b>	<b>6,845,837,071.80</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,589,093,784.55	5,082,719,603.68
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,023,012,841.52	1,720,741,708.12
33500	<b>Бусад авлага</b>	<b>44,278,711.44</b>	<b>42,375,760.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	44,278,711.44	42,375,760.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>19,178,069.61</b>	<b>38,395,976.71</b>
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>19,178,069.61</b>	<b>38,395,976.71</b>
35410	Бичиг хэргийн материал	1,713,440.01	5,292,500.01
35420	Аж ахуйн материал	14,087,090.00	28,507,868.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,281,980.00	0
35440	Түлш, шатах тослох материал	120,000.00	2,195,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,975,559.60	2,400,608.70
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>433,021,803.96</b>	<b>447,483,616.54</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>433,021,803.96</b>	<b>447,483,616.54</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>407,821,803.96</b>	<b>411,758,462.95</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	351,060,639.99	351,060,639.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,628,844.14	-59,621,032.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,900,000.00	13,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-69,900,000.00	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	194,885,183.38	128,695,910.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-103,769,104.82	-34,202,167.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,224,100.00	48,437,164.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,950,170.45	-36,592,050.99
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>25,200,000.00</b>	<b>35,725,153.59</b>
39301	Програм хангамж	5,427,586.00	11,025,153.60
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,427,586.00	-500,000.01
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>13,653,629,814.26</b>	<b>16,914,592,841.80</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>174,216,482.36</b>	<b>485,440,935.84</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>174,216,482.36</b>	<b>485,440,935.84</b>
41300	<b>Өглөг</b>	<b>14,071,428.49</b>	<b>43,746,606.24</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	14,071,428.49	43,746,606.24
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>160,145,053.87</b>	<b>441,694,329.60</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	160,145,053.87	441,694,329.60
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,479,413,331.90</b>	<b>16,429,151,905.96</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>13,479,413,331.90</b>	<b>16,429,151,905.96</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	366,264,211.87	366,264,211.87
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	366,264,211.87	366,264,211.87
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>13,090,503,972.63</b>	<b>16,040,242,546.69</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	12,535,477,614.84	13,095,051,879.63
51220	Тайлант үеийн үр дүн	555,026,357.79	2,945,190,667.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,645,147.40	22,645,147.40
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>13,653,629,814.26</b>	<b>16,914,592,841.80</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>86,186,476,613.72</b>	<b>106,570,832,939.51</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>58,105,397,906.17</b>	<b>78,666,729,837.46</b>
112	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>58,105,397,906.17</b>	<b>78,666,729,837.46</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,412,806,943.71	53,382,074,646.17
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,144,740,698.62	5,618,104,091.78
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,059,748,028.15	5,511,647,606.37
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	821,566,887.59	1,123,860,839.10
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	9,666,535,348.10	13,031,042,654.04
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>86,932,011.55</b>	<b>192,013,777.01</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>86,932,011.55</b>	<b>192,013,777.01</b>
120002	Хүүгийн орлого	695,869.30	86,793,626.42
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>37,909,821.25</b>	<b>38,937,973.70</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,866,821.25	38,937,973.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,000.00	0.00
120009	Бусад орлого	48,326,321.00	32,947,246.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	33,334,930.89
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>27,994,146,696.00</b>	<b>27,712,089,325.04</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>9,773,588,370.00</b>	<b>12,095,011,825.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,773,588,370.00	12,095,011,825.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>35,935,400.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	34,935,400.00
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>17,510,139,626.00</b>	<b>14,365,917,100.04</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,510,139,626.00	14,365,917,100.04
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>708,418,700.00</b>	<b>1,215,225,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	701,583,100.00	1,215,225,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,835,600.00	0.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>85,631,450,255.93</b>	<b>103,625,642,272.45</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>85,631,450,255.93</b>	<b>103,625,642,272.45</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>691,999,911.65</b>	<b>1,129,941,741.99</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>516,739,821.23</b>	<b>875,496,816.74</b>
210101	Үндсэн цалин	373,254,045.36	537,398,666.53
210102	Нэмэгдэл	62,684,997.00	210,108,702.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,060,000.00	37,757,000.00
210104	Урамшуулал	53,740,778.87	90,232,448.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,413,236.10</b>	<b>110,141,321.34</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,619,839.75	76,418,006.01
210202	Тэтгэмжийн даатгал	5,354,585.03	8,979,694.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,125,404.49	7,020,955.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,513.21	1,591,187.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,292,893.62	16,131,476.74
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,849,441.41</b>	<b>34,853,961.31</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,668,744.41	6,332,412.73
210302	Түлш, халаалт	22,505,901.00	26,743,212.58
210303	Цэвэр, бохир ус	1,674,796.00	1,778,336.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,433,349.25</b>	<b>27,996,828.85</b>
210401	Бичиг хэрэг	4,974,800.00	10,425,540.00
210402	Тээвэр, шатахуун	9,946,000.00	7,322,665.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,409,974.25	3,849,196.35

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,862,575.00	2,803,150.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	3,356,277.50
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,199,850.00</b>	<b>4,729,310.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	49,500.00
210604	Урсгал засвар	6,199,850.00	4,679,810.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,752,900.00</b>	<b>8,550,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,752,900.00	8,550,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,411,742.10</b>	<b>28,958,185.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,557,200.00	17,090,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,937,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,398,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,082.00	126,582.00
210807	Газрын төлбөр	44,400.00	50,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,997,644.00	5,381,080.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,335,416.10	972,973.40
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,199,571.56</b>	<b>39,215,118.35</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,443,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,299,571.56	37,772,118.35
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>84,939,450,344.28</b>	<b>102,495,700,530.46</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,638,650,616.00</b>	<b>83,949,614,032.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,600,584,773.00	83,912,012,637.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,660,408.00	7,724,195.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,405,435.00	29,877,200.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>15,300,799,728.28</b>	<b>18,546,086,498.46</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,300,799,728.28	18,546,086,498.46
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>555,026,357.79</b>	<b>2,945,190,667.06</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>555,026,357.79</b>	<b>2,945,190,667.06</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>86,767,575,825.87</b>	<b>106,736,875,245.88</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>57,746,314,772.59</b>	<b>76,208,401,013.71</b>
112	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>57,746,314,772.59</b>	<b>76,208,401,013.71</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,182,192,983.50	51,723,970,869.73
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,118,485,364.04	5,440,773,403.82
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,030,856,356.12	5,337,101,530.33
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	817,718,579.23	1,087,008,836.55
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	9,597,061,489.70	12,619,546,373.28
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>107,809,753.28</b>	<b>205,369,832.17</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>107,809,753.28</b>	<b>205,369,832.17</b>
120002	Хүүгийн орлого	695,869.30	86,793,626.42
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>107,113,883.98</b>	<b>118,576,205.75</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	107,070,883.98	118,576,205.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,000.00	0.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>28,913,451,300.00</b>	<b>30,323,104,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>10,751,805,100.00</b>	<b>14,716,563,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,751,805,100.00	14,716,563,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>35,935,400.00</b>

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	34,935,400.00
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>17,451,227,500.00</b>	<b>14,355,380,700.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,451,227,500.00	14,355,380,700.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>708,418,700.00</b>	<b>1,215,225,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	701,583,100.00	1,215,225,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,835,600.00	0.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>85,637,067,466.45</b>	<b>103,689,043,672.31</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>85,637,067,466.45</b>	<b>103,689,043,672.31</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>663,157,432.44</b>	<b>1,109,616,071.29</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>516,873,879.87</b>	<b>875,362,758.10</b>
210101	Үндсэн цалин	375,171,253.20	509,364,942.12
210102	Нэмэгдэл	62,300,450.00	238,955,262.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,832,000.00	37,258,249.60
210104	Урамшуулал	52,570,176.67	89,784,304.14
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,413,236.91</b>	<b>110,141,320.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,619,840.56	76,818,999.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,354,585.03	8,977,236.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,125,404.49	6,958,229.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,513.21	1,569,286.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,292,893.62	15,817,568.71
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,849,441.41</b>	<b>34,853,961.31</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,668,744.41	6,332,412.73
210302	Түлш, халаалт	22,505,901.00	26,743,212.58
210303	Цэвэр, бохир ус	1,674,796.00	1,778,336.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,221,798.25</b>	<b>43,461,509.35</b>
210401	Бичиг хэрэг	4,804,600.00	12,602,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,397,000.00	9,397,665.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,409,974.25	3,849,196.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,370,224.00	17,372,348.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,069,850.00</b>	<b>5,787,310.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,870,000.00	1,107,500.00
210604	Урсгал засвар	6,199,850.00	4,679,810.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,752,900.00</b>	<b>8,550,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,752,900.00	8,550,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,076,326.00</b>	<b>30,016,012.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,557,200.00	19,121,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,937,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,398,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,082.00	126,582.00
210807	Газрын төлбөр	44,400.00	50,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,997,644.00	5,381,080.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,900,000.00</b>	<b>1,443,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,443,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>84,973,910,034.01</b>	<b>102,579,427,601.02</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,673,110,305.73</b>	<b>84,033,341,102.56</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,603,460,938.00	83,888,932,916.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,660,408.00	7,724,195.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,583,524.73	106,806,791.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,405,435.00	29,877,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,300,799,728.28	18,546,086,498.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,300,799,728.28	18,546,086,498.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,130,508,359.42	44173,047,831,573.57
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	10,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	10,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	10,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	10,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-10,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,130,508,359.42	3,037,831,573.57
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,414,536,243.76	6,545,044,603.18
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,545,044,603.18	9,582,876,176.75

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	12,535,616,423.84	12,924,525,783.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-138,809.00	-138,809.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	12,535,477,614.84	12,924,386,974.11
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	555,026,357.79	555,026,357.79
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	13,090,503,972.63	13,479,413,331.90
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	13,090,503,972.63	13,479,413,331.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,547,907.00	4,547,907.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	13,095,051,879.63	13,483,961,238.90
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,945,190,667.06	2,945,190,667.06
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	16,040,242,546.69	16,429,151,905.96

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/Төгрөгөөр/ ЗГСУМС гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,719,329,700.00	85,117,021,773.85	1,116,138,386.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,719,329,700.00	85,117,021,773.85	1,116,138,386.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,184,937,700.00	1,083,680,671.29	1,078,536,991.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	934,594,800.00	853,162,758.10	853,162,758.10
210101	Үндсэн цалин	511,521,300.00	509,364,942.12	509,364,942.12
210102	Нэмэгдэл	258,759,200.00	216,755,262.24	216,755,262.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,389,000.00	37,258,249.60	37,258,249.60
210104	Урамшуулал	115,925,300.00	89,784,304.14	89,784,304.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,244,300.00	107,405,920.53	107,405,920.53
210201	Тэтгэврийн даатгал	79,726,200.00	74,797,999.31	74,797,999.31
210202	Тэтгэмжийн даатгал	9,379,500.00	8,755,236.47	8,755,236.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,503,600.00	6,780,629.16	6,780,629.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,875,900.00	1,528,486.88	1,528,486.88
210205	Эрүүл мэндийн даатгал	18,759,100.00	15,543,568.71	15,543,568.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,515,600.00	34,853,961.31	34,853,961.31
210301	Гэрэл, цахилгаан	7,872,500.00	6,332,412.73	6,332,412.73
210302	Түлш, халаалт	26,800,000.00	26,743,212.58	26,743,212.58
210303	Цэвэр, бохир ус	1,843,100.00	1,778,336.00	1,778,336.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,556,500.00	43,461,509.35	43,461,509.35
210401	Бичиг хэрэг	12,630,500.00	12,602,300.00	12,602,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,399,300.00	9,397,665.00	9,397,665.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,852,400.00	3,849,196.35	3,849,196.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,300.00	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,375,000.00	17,372,348.00	17,372,348.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,086,400.00	5,787,310.00	5,787,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,405,400.00	1,107,500.00	1,107,500.00
210604	Урсгал засвар	4,681,000.00	4,679,810.00	4,679,810.00
2107	Томилолт, зочны зардал	11,192,100.00	8,550,200.00	8,550,200.00
210702	Дотоод албан томилолт	11,192,100.00	8,550,200.00	8,550,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,848,000.00	29,016,012.00	23,872,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,748,200.00	18,121,750.00	18,121,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,937,500.00	3,937,500.00	3,937,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,398,700.00	1,398,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	126,582.00	126,582.00

210807	Газрын төлбөр	51,000.00	50,400.00	50,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,561,300.00	5,381,080.00	237,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,900,000.00</b>	<b>1,443,000.00</b>	<b>1,443,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,443,000.00	1,443,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>86,534,392,000.00</b>	<b>84,033,341,102.56</b>	<b>37,601,395.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,534,392,000.00	84,033,341,102.56	37,601,395.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,496,780,800.00	83,888,932,916.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,734,000.00	7,724,195.00	7,724,195.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	106,806,791.56	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,877,200.00	29,877,200.00	29,877,200.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>87,719,329,700.00</b>	<b>92,159,678,905.75</b>	<b>1,215,225,000.00</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>14,716,563,300.00</b>	<b>14,716,563,300.00</b>	<b>1,215,225,000.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	14,716,563,300.00	14,716,563,300.00	1,215,225,000.00
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>73,002,766,400.00</b>	<b>77,324,539,400.00</b>	<b>0.00</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	73,002,766,400.00	64,704,993,026.72	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	12,619,546,373.28	0.00
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>118,576,205.75</b>	<b>0.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	118,576,205.75	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,545,044,603.19	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	9,582,876,176.76	0.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>85.00</b>	<b>79.00</b>	<b>0.00</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>42.00</b>	<b>39.00</b>	<b>0.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	5.00	0.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>42.00</b>	<b>39.00</b>	<b>0.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.00	31.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00	0.00

Нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.0	35,935,400.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	25,935,400.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	25,935,400.00	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	22,200,000.00	-
210102	Нэмэгдэл	0.0	22,200,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	2,735,400.00	-2,735,400.00
210201	Тэтгэврийн даатгал	0.0	2,021,000.00	-2,021,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	222,000.00	-222,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	177,600.00	-177,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	40,800.00	-40,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	274,000.00	-274,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	1,000,000.00	-1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	1,000,000.00	-1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	10,000,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	10,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	10,000,000.00	-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	35,935,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	35,935,400.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.0	1,000,000.00	-1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	34,935,400.00	-

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 1,678.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрсэн. Аудитын явцад 1,282.0 мянган төгрөгийн алдааг залруулга хийж 396.5 мянган төгрөгийн залруулаагүй дүн дээр нягтлан бодогчоос тайлбар авсан.

### 5.1. Залруулсан алдаа

1. Бараа материалын ангиллын дагуу бүртгээгүй 1,282.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус залруулж бүртгэсэн. Бичиг хэргийн дансанд бүртгэлтэй 2 нэр төрлийн хөрөнгийг тооллогоор цаашид ашиглах боломжгүй гэж үзэж данснаас хассан. Хүчингүй болсон хуулийн ном учраас хассан байна. Энэ нь *Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.15-д “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно”, 4.16-д –“Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитаар 2 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

### 5.2. Төлбөрийн акт

Тайлант оны аудитаар тогтоосон төлбөрийн акт байхгүй болно.

### 5.3. Албан шаардлага

Тайлант оны аудитаар тогтоосон албан шаардлага байхгүй болно.

### 5.4. Зөвлөмж

Тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1.8 сая төгрөгийн орлогын 18 гүйлгээ, 6.0 сая төгрөгийн 8 зарлагын гүйлгээ, 138.1 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 30 тушаал байршуулахаас 125.1 сая төгрөгийн 5 шийдвэрийг хуулийн хугацаанд нь мэдээлээгүй байна.

Иймд системд мэдээлсэн байдлын хэрэгжилт 87.5 хувьтай, хугацаа хоцролт 79.0 хувьтай байгаа нь мэдээллийн ил тод байдал алдагдах, хуулийн хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.5-т *“цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”*, 6.4.8-т *“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч,*

хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт”, 8.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны системд мэдээлэх мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж цаашид хуулийг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Мянган  
төгрөгөөр  
/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Заглуулсан		Заглуулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	-	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал буруу тооцоолсон	1	1,068.4	1	1,068.4			1	1,068.4				
Бараа материалын ангиллын дагуу бүртгээгүй	1	1,678.6			1	1,678.6	1	1,282.0	1	396.5		



